



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

АРХАНГАЙ АЙМГИЙН
АЙМАГ, СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МОНГОЛ АРДЫН
НАМД

2024.08.08 № 338

танай _____ -ны № _____ -т

Г Дүгнэлт хүргүүлэх тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, 37.10, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4 дэх хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Архангай аймгийн аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох "Монгол ардын нам"-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох

байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

“Монгол ардын нам”-ын Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгасан зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

“Монгол ардын нам”-ын мөрийн хөтөлбөр (..... хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: “Архангай аймгийн сонгуулийн хороо”-нд

Хавсралт¹² хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.БАЙГАЛМАА



Архангай аймгийн Монгол Ардын Намын
хорооны 2024 оны 06 дугаар сарын 25-ний
өдрийн 24 дугаар тоот албан бичгийн
Хавсралт



“АРХАНГАЙН ХӨГЖИЛ” 2024-2028

АРХАНГАЙ АЙМГИЙН МОНГОЛ АРДЫН НАМААС ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Архангай аймгийн Монгол Ардын намын хороо 2024 оны Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд “ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГО-БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ” 5 бүлэг 28 дэд бүлэг 270 заалт бүхий Мөрийн хөтөлбөрийг дэвшүүллээ.

НЭГ. ХҮНИЙ ХӨГЖИЛ

1.1 Хөдөлмөр эрхлэлт

- 1.1.1 Шинээр ажлын байрыг нэмэгдүүлж, иргэдийн орлоготой болох нөхцөлийг бүрдүүлж ажилгүйдлийн түвшинг бууруулна. /100 ажлын байр бүхий оёдлын үйлдвэр, хөнгөн үйлдвэрийг шинээр байгуулна. /
- 1.1.2 Бага, дунд орлоготой иргэдийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.1.3 Өрхийн бичил бизнесийг дэмжих, хүүгүй, барьцаагүй санхүүгийн дэмжлэг үзүүлэх бодлогыг үргэлжлүүлнэ.
- 1.1.4 Гарааны бизнес эрхлэгч оюутан, залууст бизнесээ тэлэх эрчимжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар олгох цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 1.1.5 Гарааны бизнес эрхлэгчдэд зориулсан орчин үеийн санхүүжилтийн хэлбэрүүдийг нэвтрүүлж санхүүгийн үр ашигтай тогтолцоог бүрдүүлнэ.
- 1.1.6 Орлого багатай өрхийн ажил эрхлээгүй насанд хүрсэн гишүүдийг мэргэшил эзэмшүүлэх үр чадварыг ахиулах сургалтад хамруулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.
- 1.1.7 Залуучууд, залуу гэр бүлийг орлогод нь нийцсэн, уян хатан төлбөрийн нөхцөлтэй орон сууцанд хамруулах бодлого баримтлана.
- 1.1.8 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, дундаж орлоготой өрхийн эзлэх хувийг нэмэгдүүлнэ.

1.2 Эрүүл мэнд

- 1.2.1 Нэгдсэн эмнэлгийн оношилгооны чадавхыг дээшлүүлж, иргэн бүр эрүүл мэндийн бүрэн оношилгоонд жил бүр заавал хамрагдах тогтолцоог бүрдүүлнэ.
- 1.2.2 АШҮҮИС-ийн харьяа “Сувилахуйн сургалт, эрдэм шинжилгээ, эмнэлзүйн цогцолбор”-ыг байгуулж, бус нутгийн хэмжээнд бага эмч, сувилагч, мэргэжилтнүүдийг орон нутагтаа бэлтгэнэ.

- 1.2.3 “Эрүүл шүд-Архангай”, “ Эрүүл зүрх-Архангай” хөтөлбөрийг хэрэгжүүлж, хүн амын нас, хүйс, эрсдэлд суурилсан эрт илрүүлэг үзлэгийг эрчимжүүлж, хавдраас сэргийлэх цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 1.2.4 Аймгийн Нэгдсэн эмнэлэгт ангиограммын болон осол гэмтлийн мэс заслын шинэ технологи нэвтрүүлэн, эмч мэргэжилтнүүдийг багаар нь сургаж чадавхжуулна.
- 1.2.5 “Нийгмийн эрүүл мэндийн төв”-ийг байгуулан, салбар дундын оролцоог нэмэгдүүлнэ..
- 1.2.6 Анхдагч болон хоёрдогч шатлалын лавлагаат тусlamж үйлчилгээнд шинэ технологи бүхий оношилгоо, эмчилгээ үйлчилгээг нэвтрүүлж, үйлчилгээний ээлтэй байдлыг ханган, өвчлөл, нас барагтыг бууруулна.
- 1.2.7 Тусгай хэрэгцээ /хөгжлийн бэрхшээл/-тэй иргэдийн эрх, оролцоог хангаж, нөхөн сэргээх эмчилгээ, сувилгаа болон хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.
- 1.2.8 Анхан шатны Эрүүл мэндийн байгууллагад дижитал эрүүл мэндийн технологи нэвтрүүлнэ.
- 1.2.9 Нөхөн сэргээлт, фитнесс, спортын төвүүдийн үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй болгож идэвхтэй дасгал хөдөлгөөнийг амьдралын хэв маяг болгон эрүүл амьдрах нөхцөлийг бүрдүүлж бүх нийтийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлнэ.
- 1.2.10 Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой иргэдэд эмнэлгийн тусlamж, үйлчилгээ авах боломжийг нэмэгдүүлнэ.
- 1.2.11 Эх, хүүхдийн эндэгдлийг бууруулна.
- 1.2.12 Сэргээх засал, тусlamж, үйлчилгээ, уламжлалт анагаах ухааныг хөгжүүлнэ.
- 1.2.13 Булган, Цэнхэр, Жаргалант, Цэцэрлэг, Өгийнуур сумдад эрүүл мэндийн төв шинээр барина.

1.3 Боловсрол

- 1.3.1 Багш нарын мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжиж, мэргэжил дээшлүүлэх гадаад, дотоодын сургалт, үйл ажиллагааг дэмжин “Багшийн хөгжил” хөтөлбөрийг үргэлжлүүлнэ.
- 1.3.2 Хүүхэд бүрийг сургуулийн өмнөх боловсролд хамруулж, цэцэрлэгт 2 ээлжийн бүлгийн багш ажиллуулан бүлэг дүүргэлтийг стандартын түвшинд байлгана.
- 1.3.3 Суралцаачдад сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх, мэргэжлээ сонгоход туслах чиг үүрэгтэй сэтгэл зүйч-мэргэжилтнийг сургууль бүрд ажиллуулна.
- 1.3.4 Хүүхдийн сонирхол авьяас чадварыг нээн хөгжүүлэх сонгон суралцах секц, дугуйлангийн үйл ажиллагааг өргөжүүлнэ.
- 1.3.5 Сургууль бүрд байгалийн ухаан, технологийн хичээлийн лаборатори, туршилтын талбай байгуулна.
- 1.3.6 “Шинжлэх ухаан инновацын төв”-ийг байгуулж, шинжлэх ухаанд суурилсан төсөл, хөтөлбөрүүдийг дэмжинэ.
- 1.3.7 Сурч боловсрох, ажиллах орчин, нөхцөл боломжийг сайжруулж хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэн сургууль, цэцэрлэгийг “Хүний хөгжлийн төв” болгоно.
- 1.3.8 Зарим сумдад сургууль, цэцэрлэг шинээр барих, их засварт оруулна.
- 1.3.9 Мэргэжлийн сургуулиудад чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр нэвтрүүлж, хөдөлмөрийн зах зээл дэх мэргэжилтэй ажиллах хүчний хэрэгцээг хангана.
- 1.3.10 Хүүхэд харах үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, 1-2 хүртэлх насны хүүхдийг хамруулах боломжтой болгож, яслийн үйлчилгээг сэргээнэ.

1.3.11 Төрийн болон хувийн хэвшлийн хамтын ажиллагаан дээр түшиглэн өрсөлдөх чадвартай мэргэжилтэн ажилтан бэлтгэнэ.

1.4 Хүүхэд, залуучууд, гэр бүл

- 1.4.1 Хүүхдийн хөгжил, авьяас, ур чадвар, техник сэтгэлгээ, нийгмийн төлөвшилтийг дэмжихэд эцэг, эхчүүдийн оролцоог нэмэгдүүлнэ.
- 1.4.2 Хүүхдийн тоглоомын талбай, орчны стандартыг бүхий л шатанд мөрдүүлж, хүүхдэд аюулгүй орчин бүрдүүлж, түүнд тавигдах хяналтыг сайжруулна.
- 1.4.3 Булган хангай хороололд “Хүүхэд, залуучуудын парк” -ыг байгуулна.
- 1.4.4 Хүүхэд хөгжлийн ордонг ашиглалтад оруулж, үйл ажиллагааг жигдрюүлнэ.
- 1.4.5 Хүүхдүүдэд ахуйн боловсрол олгох, зан, заншил, малч ухааныг таниулах зорилгоор “Хөдөлмөр зуслан” хөгжлийн хөтөлбөрийг үргэлжлүүлнэ.
- 1.4.6 Хүүхэд, гэр бүлийг хүчирхийллээс хамгаалах цогц арга хэмжээний цар хүрээг нэмэгдүүлнэ.
- 1.4.7 “Сурагч солилцоо” хөтөлбөрийг бүс нутгийн хэмжээнд зохион байгуулна.
- 1.4.8 Сум бүрд хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан ажиллуулна.
- 1.4.9 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн “Хөгжлийн төв”-тэй болгоно.
- 1.4.10 Хүүхдийн “Тамир зуслан”-г өргөтгөж нэг ээлждээ 300 хүүхэд хүлээн авах хүчин чадал бүхий хүүхдийн зуслан болгоно.
- 1.4.11 “Аялагч хүүхэд” хөтөлбөрийг үргэлжлүүлэн, бүс нутгийн хэмжээнд зохион байгуулахад шаардлагатай бүхий л дэмжлэгийг авч ажиллана.
- 1.4.12 “Өв тээгч хүүхэд” хөтөлбөр хэрэгжүүлнэ.

1.5 Ахмад настан

- 1.5.1 Ахмад настны чөлөөт цагаа үр дүнтэй өнгөрөөх, мэдээлэл авах, хөгжих боломжийг бүрдүүлэх хөгжлийн төвүүдийг нэмж байгуулна.
- 1.5.2 Ахмад настны орлогыг нэмэгдүүлэх, мэдлэг туршлагага залуучуудад өвлүүлж үлдээх ажил эрхлэлт, зөвлөх үйлчилгээг үр дүнтэй хэлбэрээр үргэлжлүүлнэ.
- 1.5.3 Ахмадын шинэ өргөө “Хүний хөгжлийн ордон” байгуулна.
- 1.5.4 Ахмадын сувиллын менежментийг шинэчлэн сайжруулж, орчин үеийн шаардлагад нийцсэн сэргээн засах, сувиллын үйлчилгээг үзүүлнэ.

1.6 Соёл, урлаг, спорт

- 1.6.1 Түүх, соёлын өвийг сүйтгэж байгаа хууль бус ажиллагаатай хатуу тэмцэж, хариуцлагыг чангатгаж, биет болон биет бус өвийг хамгаална.
- 1.6.2 Нутгийн иргэдэд түшиглэсэн “Соёлын биет өвийг хамгаалах” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.6.3 Заяын хүрээний Цогчин дуганыг сэргээн засварлана.
- 1.6.4 Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэн, соёл урлагийн байгууллагуудын орлогыг нэмэгдүүлэн, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.6.5 Эрдэнэбулган сумын багуудад спорт заал шинээр барьж нийтийн биеийн тамирыг хөгжүүлж, эрүүл чийрэг бие бялдартай иргэдийн тоог нэмэгдүүлнэ.
- 1.6.6 Мэргэжлийн спортыг төрөлжүүлэн хөгжүүлнэ.

- 1.6.7 Спортын дасгалжуулагчдыг мэргэшүүлэх сургалтын тогтолцоог сайжруулж, биийн тамир, спортын арга зүйчийг сум бүрд ажиллуулах бодлого баримтлана
- 1.6.8 Соёл, урлагийн салбарын менежментийг сайжруулж, орон нутгийн онцлогт тулгуурласан ардын урлагийг хөгжүүлнэ.
- 1.6.9 Сумдад соёлын төв барих, их засвар хийх ажлыг үргэлжлүүлнэ.

ХОЁР: ЭДИЙН ЗАСАГ

2.1 Хөдөө аж ахуй

- 2.1.1 Тариалангийн талбайд ойн зурvas байгуулах, хөрсний элэгдэл, эвдрэлээс сэргийлэх, хөрсний үржил шимийг сайжруулах ажлыг зохион байгуулна.
- 2.1.2 Мэргэжлийн байгууллага, мэргэжилтнүүдтэй хамtran шинжлэн ухааны үндэслэлтэйгээр бэлчээрийн мал аж ахуйг эрчимжсэн мал аж ахуйтай хослуулан хөгжүүлнэ.
- 2.1.3 Орон нутгийн онцлог, түүхий эдийн нөөцд тулгуурлан хүнсний болон, сүү, цагаан идээний үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.
- 2.1.4 Мал, амьтны гаралтай арьс, шир, ноос, ноолуур, хөөврийг боловсруулах, оёмол, сүлжмэл бэлэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжиж, хөгжүүлнэ.
- 2.1.5 "Монгол мал" хөтөлбөрийг хэрэгжүүлж, малыг эрүүлжүүлэх, чанар, ашиг шимийг сайжруулах ажлыг эрчимжүүлж, малын тоог чанарт шилжүүлж ашиг шим, хүртээмжийг сайжруулах, малын гений санг хамгаалах, биотехнологийн ололтыг нэвтрүүлнэ.
- 2.1.6 Малын их эмч, зоо-техникчдийг үе шаттайгаар бэлтгэн, хөдөө орон нутагт ажиллуулж, малыг эрүүлжүүлэх, олон улсын стандартад нийцүүлэх ажлыг зохион байгуулж "Эрүүл малтай аймаг" болно.
- 2.1.7 Мал маллах, газар тариалан эрхлэх уламжлалт арга ухааныг шинжлэх ухааны ололттой хослуулан малчид, тариаланчдыг мэргэшүүлж, залгамж халааг бэлтгэх ажлыг үе шаттай зохион байгуулна.
- 2.1.8 Нийт сүрэгт цөм сүргийн эзлэх хувийг нэмэгдүүлж, эрчимжсэн загвар, цогцолбор аж ахуйг олноор бий болгох, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, бэлтгэн нийлүүлэлт, хадгалалт, тээвэрлэлт, борлуулалтын сүлжээг бий болгоно.
- 2.1.9 Бэлчээрийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, даац багтаамжийг тохируулахад чиглэсэн газар зохион байгуулалтын төлөвлөлт хийж, сум дундын отрын бүс нутаг, нөөц бэлчээртэй болох, хортон мэрэгчтэй тэмцэх оновчтой менежментийг нэвтрүүлнэ.
- 2.1.10 Газар тариалангийн үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлж малчид, тариаланчид, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэдийг дэмжин, "Техник үйлчилгээний төв"-ийг байгуулан ажиллана.
- 2.1.11 Инновац, өндөр технологи, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үйлчилгээ, дахин боловсруулах, эко үндэсний брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэгчийг болон бүтээлч аж үйлдвэрлэлийг төрөөс бодлогоор дэмжинэ.
- 2.1.12 Гахай, тахиа, зөгийн туслах аж ахуй эрхлэх хувийн хэвшлийн санаачилгыг бодлогоор дэмжинэ.
- 2.1.13 Дөрвөн улирлын хүлэмж, агуулах, зоорины хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлж хүнсний ногоо, жимс жимсгэнийн хадгалалтыг сайжруулан, дотоодын хэрэгцээг жилийн турш тогтвортой хангана.
- 2.1.14 Бэлчээрийн мал аж ахуйд зохистой сүргийн бүтэц, ашиг шимт байдал, байгальд ээлтэй мал маллах зөв дадлуудыг нэгтгэсэн стандартыг нэвтрүүлж, бэлчээрийн доройтлыг бууруулна.

- 2.1.15 Малыг ялган тэмдэглэх, бүртгэлжүүлэх ажлыг эрчимжүүлж, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан, малын гаралтай бүтээгдэхүүний мөшгөх цахим тогтолцоог төгөлдөржүүлнэ.
- 2.1.16 “Архангайд үйлдвэрлэв” худалдаа, үйлчилгээний төвийн үйлчилгээг өргөтгөж, бүтээгдэхүүнээ сурталчлах, зах зээлд нийлүүлэх, борлуулах сувгуудыг нээж өгнө.
- 2.1.17 Мал аж ахуйн түүхий эдэд түшиглэн хөнгөн үйлдвэрийн дамжлагат цогцолборууд бий болгож хөгжүүлнэ.
- 2.1.18 “Ахуй үйлчилгээний төв”-тэй болно.

2.2 Аялал жуулчлал

- 2.2.1 “GoMongolia” арга хэмжээний хүрээнд байгаль, түүх, соёл, уламжлал, ёс заншил, нүүдэлчин ахуйн үнэт өв, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг орон нутгийн онцлогт тохируулан, хөгжүүлнэ.
- 2.2.2 Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор “Winter land” мөсөн наадмыг жил бүр уламжлал болгон зохион байгуулна.
- 2.2.3 Аялал жуулчлалын төвийн үйл ажиллагааны менежментийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд зохион байгуулж, аялал жуулчлалыг хөгжүүлнэ.
- 2.2.4 Цэцэрлэг хотыг “Аялал жуулчлалын хот” болгон хөгжүүлж, төв гудамжинд худалдаа үйлчилгээ эрхлэх орчин нөхцөлийг бүрдүүлнэ.
- 2.2.5 Орон нутгийн онцлог, ялгарал бүхий байгаль орчинд ээлтэй, нутгийн иргэдийг түшиглэсэн “Малчин кемп” аялал жуулчлалыг хөтөлбөрийг өргөжүүлнэ.
- 2.2.6 Аялал жуулчлалын үйлчилгээний чанар, эрүүл ахуйн шаардлагыг сайжруулна.
- 2.2.7 Байгалийн үзэсгэлэнт түүхэн дурсгалт газар, халуун рашаан түшиглэн “Хангайн бүсийн” аялал жуулчлалын төв болгох ажлыг эрчимжүүлж үзвэр үйлчилгээг сайжруулна.
- 2.2.8 Байгаль, түүх, нүүдэлчний ахуй соёл, шашин, урлагт түшиглэсэн аялал жуулчлалын гадаад, дотоодын сүлжээг бий болгон, аялагч, жуулчдын сонирхлыг татсан аяллын төрлүүдийг бус нутгаар төрөлжүүлэн хөгжүүлж, 4 улирлын аялал жуулчлалын маршрут, хөтөлбөр боловсруулна.
- 2.2.9 “Тогтвортой аялал жуулчлал” дэд хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж, жуулчин хүлээн авах хүчин чадлыг нэмэгдүүлэн, аялал жуулчлалын гол бус нутагт дэд бүтэц үйлчилгээний цогцолборуудыг барьж байгуулан олон улсын стандарт шаардлагад нийцүүлэн хөгжүүлнэ.

2.3 Дэд бүтцийн талаар

- 2.3.1 Архангай аймгийн төв Цэцэрлэг хотод дулааны станц барьж, агаарын бохирдлыг бууруулна.
- 2.3.2 Цэцэрлэг хотын авто замыг бүрэн шинэчилж, хатуу хучилттай авто замын сүлжээг нэмэгдүүлнэ.
- 2.3.3 Булган хангай хороололд 1000 айлын орон сууц хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 2.3.4 Амины орон сууц /хаус хороолол/-ыг барина.
- 2.3.5 Бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд бүсийн аймгуудыг авто замаар холбоно.
- 2.3.6 Мянганы замын Орхоны гүүр - Батцэнгэл чиглэлийн 70 км авто замыг барина
- 2.3.7 Мянганы замын Батцэнгэл-Цагаандавааны ар хормой чиглэлийн 65 автозамыг барина.

- 2.3.8 Цахир, Хайрхан, Булган сумын төв дотор 1.5 км хатуу хучилттай автозам барина.
- 2.3.9 Улсын чанартай Хархорин-Цэцэрлэг чиглэлийн А 0602 дугаартай хатуу хучилттай авто зам дээр шинэчилсэн их засвар хийнэ.
- 2.3.10 Улсын чанартай Цэцэрлэг-Тосонцэнгэл чиглэлийн А 0603 дугаартай авто зам дээр 40 км шинэчлэлийг хийнэ.
- 2.3.11 Цахир сумын Гэсэр багш, Цэнхэрийн халуун рашаан, Их тамир сумын Тайхар чулуу руу чиглэсэн аялал жуулчлал түшиглэсэн гол газруудыг хатуу хучилттай авто замаар холбох ажлыг хэрэгжүүлнэ.
- 2.3.12 Орон нутгийн үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа, бирж, тээвэр логистикийн цогцолборыг кластераар хөгжүүлэх тохиромжтой байршлыг санал болгож, хүсэлт гаргасан хувийн хэвшил, шинэ хоршоодыг дэмжинэ.
- 2.3.13 Архангай аймгийн Хашаат, Өгийнуур сумдын нутаг дэвсгэрийг хамарсан Орхон голын сав, Хангайн нурууны экосистемд түшиглэсэн рашаан сувилал, адал явдалт, түүх соёлын аяллыг хөгжүүлэх “Шинэ Хархорум” аялал жуулчлалын кластер бүсчлэлээр хөгжүүлнэ.
- 2.3.14 Өгийнуур орчимд археологийн нөөцөд түшиглэн аялал жуулчлалын тусгай бүсийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулна.
- 2.3.15 Урд тамирын голд төмөр бетон гүүрийг барьж ашиглалтад оруулна.
- 2.3.16 Бэлчээр худаг, уст цэгийг барих ажлыг үргэлжлүүлнэ.
- 2.3.17 Шинэ суурьшлын бүсүүдэд инженерийн дэд бүтцийг шийдвэрлэнэ.
- 2.3.18 Төвлөрсөн инженерийн байгууламжийг сумдад бий болгоно.
- 2.3.19 Кино үзвэрийн сүүлийн үеийн техник, технологиор бүрэн тоноглогдсон кино театрыг шинээр барина.
- 2.3.20 Аймгийн музейг орчин үеийн жишигт техник, тоног төхөөрөмжөөр ханганд AR, VR зэрэг технологийн шийдлийг ашиглан тохижуулна.
- 2.3.21 Цогчин дуганыг сэргээн засварлаж Дархан цаазат Булган уулын урд хэсгийг /12 уулзвараас хойших/ соёл, шашны иж бүрэн цогцолбор болгон хөгжүүлж, аялал жуулчлалд түшиглэсэн худалдаа, үйлчилгээ эрхлэх боломжийг бүрдүүлнэ.
- 2.3.22 Аймгийн төвийн Цэцэрлэг хотод онгоцны буудлыг шинээр байгуулж, аялал жуулчлалын гол бүс нутгуудад бага оврын онгоц газардах орчин нөхцөлийг бүрдүүлнэ.
- 2.3.23 Цэцэрлэг хотын гэрэлтуүлгийг иж бүрэн шийдвэрлэнэ.
- 2.3.24 Хангай, Өгийнуур, Хашаат, Булган сумдыг төв замтай хатуу хучилттай авто замаар холбоно.
- 2.3.25 ISO 14000, ISO9001 стандартын хэрэгжилтийг хангах, хүнсний аюулгүй байдлын лабораторитой болно.
- 2.3.26 Гэр хорооллыг инженерийн төвийн шугам сүлжээнд үе шаттай холбоно.
- 2.3.27 Хотын доторх үерийн усны далан, шуудууг шинэчилж, засмал зам дагуу ус зайлзуулах сувгийг шинэчилнэ.
- 2.3.28 Аймгийн нутаг дэвсгэрт урт хугацаанд ашиглагдаж, эдэлгээ дууссан орон сууцуудыг дахин төлөвлөлтөд шат дараатай оруулах замаар шинэчлэх ажлыг зохион байгуулна.

ГУРАВ: ЗАСАГЛАЛ

- 3.1.1 Бүх нийтийн оролцоог хангасан, хууль ёс, тогтвортой хөгжлийн, иргэдийн аюулгүй амьдрах орчныг хангасан засаглалыг бэхжүүлнэ.
- 3.1.2 Төрийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааны давхардлыг арилгах, нэгтгэх замаар бүтэц, зохион байгуулалтыг оновчтой, цомхон болгоно.
- 3.1.3 Тогтвортой хөгжлийн хэтийн зорилтуудыг албан байгууллага, сумын хөгжлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлнэ.

- 3.1.4 Тогтвортой хөгжил, ногоон хөгжлийн зарчмыг мөрдөх, ногоон амьдралын хэв маягийг төрийн байгууллагуудад нэвтрүүлнэ.
- 3.1.5 Төрийн бүх шатны байгууллагын хүний нөөцийн сонгон шалгаруулалтыг нээлттэй ил тод болгоно.
- 3.1.6 Төрийн үйлчилгээг иргэдэд хүргэдэг төрийн захиргааны анхан шатны нэгж багийн төвүүдийг бэхжүүлэх “Багийн хөгжлийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлнэ.
- 3.1.7 Нэг цонхны үйлчилгээний цар хүрээг нэмэгдүүлж, явуулын нэг цэгийн үйлчилгээг өргөжүүлж, төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, хүний оролцоогүй, хиймэл оюун ухааны тусламжтайгаар хүсэлт шийдвэрлэх чадавх бүхий “Ухаалаг E-Mongolia” системийг хэрэглээг нэмэгдүүлж, иргэдэд төрийн үйлчилгээг шуурхай хүргэх ажлыг зохион байгуулна.

ДӨРӨВ: БАЙГАЛЬ ОРЧИН

- 4.1.1 Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг эрчимжүүлж айл өрх бүр эзэмшлийн газартаа мод тарих аян өрнүүлж, төрөөс үзүүлж буй дэмжлэгийг ургуулсан модны тоо, цахилгаан, усны зардалтай уялдуулна.
- 4.1.2 Байгальд ээлтэй дадал, хандлагыг олон нийтэд төлөвшүүлэн байгалийн нөөц баялгийг хамгаалах, хэмнэлттэй, үр ашигтай зүй зохистой ашиглаж нөхөн сэргээх замаар байгалийн унаган төрхийг хадгалан ногоон бүс нутаг болно.
- 4.1.3 Хүн амыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ундны усаар хангах нөхцөлийг бүрдүүлж, байгалийн тогтоц, голын татамд хур тунадас, хайлсан цас, мөсний усыг хуримтлуулах хөв цөөрөм байгуулж, ард иргэд, мал аж ахуй, зэрлэг амьтан, ус хангамж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 4.1.4 Биологийн олон янз байдлын амьдрах орчныг сайжруулж, нөөц баялгийн боломжит нөөцөд тулгуурласан ашиглалт, хамгаалалтын ажлыг хийж гүйцэтгэнэ.
- 4.1.5 Байгалийн нөөц баялгийг зүй зохистой ашиглах арга зүй, технологийн хэрэгжилт, хяналтыг сайжруулна.
- 4.1.6 Уул уурхайн олборлолтын улмаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн ажлыг үргэлжлүүлнэ.
- 4.1.7 Цөлжилттэй тэмцэх ажлыг бүх хэлбэрээр зохион байгуулна.
- 4.1.8 Ойн аж ахуйн арга хэмжээний менежментийг хэрэгжүүлж, ойн сангийн хомсдол, доройтлыг бууруулж, ойрхог чанарыг сайжруулна.
- 4.1.9 Мод үржүүлгийн төвийг шинээр байгуулна.
- 4.1.10 Биологийн олон янз байдлын амьдрах орчныг сайжруулж, нөөц баялгийн боломжит нөөцөд тулгуурласан ашиглалт, хамгаалалтын ажлыг хийж гүйцэтгэнэ.
- 4.1.11 Хог хаягдлын хэмжээг бууруулах, байгальд ээлтэй байдлаар цэвэрлэх, ангилан ялгах, дахин ашиглах, боловсруулах менежментийг нэвтрүүлнэ.
- 4.1.12 Агаарын бохирдлыг бууруулах дэд хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлнэ.
- 4.1.13 Төвлөрсөн шугам сүлжээнд холбогдоогүй газруудын ариун цэврийн байгууламжийг боловсронгуй болгох, байгальд ээлтэй технологид шилжүүлнэ.
- 4.1.14 Байгалийн нөөц баялагийг зүй зохистой ашиглах арга зүй, технологийн хэрэгжилт, хяналтыг сайжруулах эрчимжүүлнэ
- 4.1.15 Уул уурхайн олборлолтын улмаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн ажлыг эрчимжүүлнэ.

4.1.16 Гамшгийн эрсдлийн менежментийг сайжруулна.

ТАВ. СУМДЫН ХӨГЖИЛ

- 5.1.1 Бүх сум, баг, малчин өрхүүдийг интернэт, үүрэн холбооны 4G сүлжээ хүлээн авах боломжийг бүрдүүлнэ.
- 5.1.2 Сумдад төрийн албан хаагч болон зорилтот бүлгүүдэд зориулсан орон сууцыг шинээр барьж ашиглалтад оруулна.
- 5.1.3 Сумын төв доторх авто зам, явган хүний замыг шинээр тавьж, шинэчлэн сайжруулна.
- 5.1.4 Ашиглалтын хугацаа дуусч, ашиглалтын шаардлага хангахгүй болсон барилга, байгууламжтай төрийн байгууллагуудын барилгыг шинээр барьж, их засвар хийнэ.
- 5.1.5 Иргэдийн байнга зорчдог гарам дээр гүүр шинээр барьж, зам гүүрийг завсар хийх шаардлагатай гүүрийг засварлана.
- 5.1.6 Мал нядалгааны цэг, Ахуйн үйлчилгээ, Шахмал түлшний үйлдвэр байгуулахыг дэмжинэ.
- 5.1.7 Шинэ хоршоо хөдөлгөөнийг өрнүүлж хоршоолохыг дэмжинэ.
- 5.1.8 Газар тариалан эрхлэх, тэжээлийн ургамал тарих, хадлангийн бүс нутгийг тогтоож эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- 5.1.9 Сумдад цэцэрлэгт хүрээлэн, гэрэлтүүлэг, камержуулалт, халуун усны асуудлыг цогцоор нь шийдвэрлэнэ.
- 5.1.10 Худаг, уст цэгийн тоог нэмэгдүүлж, сумын төвд “Ухаалаг худаг” үйлчилгээг нэвтрүүлнэ.
- 5.1.11 Хануйн гүүрнээс Эрдэнэмандал, Хайрхан чиглэлийн авто замыг барих ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.
- 5.1.12 Бүх суманд шүдний кабинет байгуулна.

1. Эрдэнэбулган сум, /Цэцэрлэг хот/

- Цэцэрлэг хотын авто замын шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлнэ.
- Цэцэрлэг хотын 2, 3 дугаар Ээлжийн үерийн далангийн ажлыг эхлүүлж, иргэдийг үер уснаас хамгаалах ажлыг хэрэгжүүлнэ.
- Их тойруугийн хатуу хучилттай замыг барина. /Эрдэнэбулган сум Нэгдсэн эмнэлэгийн арын уулзвараас “Тамир” хорооллоор дайруулан Цагаан даваа хүртэлх зам/
- Хот тохижилт, үйлчилгээ, хог хаягдал, гудамж талбайн цэвэрлэгээ, ногоон байгууламжийн арчилгаа, тохижилтын менежментийг сайжруулна.
- Шинээр газар олгогдсон суурьшлын бүсэд дэд бүтцийг шийдвэрлэнэ.
- Явган хүний, дугуйн зам тавих, засварлах ажлыг тогтмол хэрэгжүүлнэ.
- Цэцэрлэг хотын гэрэлтүүлгийг нэмнэ.
- Гэр хорооллыг камержуулан, “Камерийн хяналтын дэд төв”-ийг байгуулна.
- Нийтийн тээвэр, таксины үйл ажиллагааг сайжруулж, стандартыг мөрдүүлнэ.

2. Хангай сум

- Сумын төвийг "Тэрхийн гол"-ын урт гүүртэй хатуу хучилттай засмар замаар холбоно.
- Сумын Засаг даргын тамгын газрын барилгыг шинээр барина.
- Сумын эрүүл мэндийн төвд өргөтгөл хийнэ.
- Багуудад үүрэн холбооны 4G сүлжээг оруулна.
- Багуудыг өндөр хүчдэлээр холбоно.

3. Ихтамир сум

- Тайхар чулууг түшиглэсэн аялал жуулчлалын төвийг шинээр бий болгоно.
- Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх зорилгоор спортын цогцолбор барина

- Төв зам дагуу "Ихтамир худалдааны төв" байгуулна.
- Иргэдийн эрүүл мэндийн тусlamж үйлчилгээг цаг алдалгүй авах нөхцөл боломжийг бүрдүүлэн, түргэн тусlamжийн автомашиныг шийдвэрлэнэ.
- Шинэ сум төслийн хүрээнд айл өрхүүдийг цэвэр бохирт холбож, дулааны шугамд холбох ажлыг эхлүүлнэ.

4. Тариат сум

- Сумын төвийн инженерийн шугам сүлжээнд өргөтгөл хийнэ.
- Ерөнхий боловсролын сургуульд их засвар хийнэ.
- Мөрөн багийн Дасгалын зам, Хөнжилийн давааны замыг төв замтай холбоно.
- Эрүүл мэндийн төвд их засвар хийнэ.
- Малчин өрхийн дэргэд "Гэр түрээс" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- Сумын Засаг даргын тамгын газрын байрыг шинээр барина.

5. Хайрхан сум

- Сургуулийн дотуур байр шинээр барина.
- Наадмын талбайг суурьшлын бүсээс гаргана.
- Сумын төвийн зам дагуух гэрэлтүүлэг, явган хүний замыг сайжруулах
- Ахмадын өргөөнд урсгал засвар хийж, ахмадуудыг чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх нөхцөл, бололцоог нэмэгдүүлнэ.
- Цэцэрлэгт хүрээлэнг тохижуулна.
- Бухын рашааныг түшиглэн аялал, жуулчлалын цогцолборийг бий болгоно.
- Хог дахин боловсруулах үйлдвэрийг шинээр бий болгоно.
- "Шинэ баг" төсөл хэрэгжүүлнэ.

6. Өлзийт сум

- Сумын төвийн албан байгууллага, гэр хорооллыг инженерийн шугам сүлжээнд холбоно.
- Сумын төвийн авто замыг Мянганы замын хэвтээ тэнхлэгтэй холбоно.
- Сумын төвийн хогийн цэгийг ландшипилын аргаар булшлах буюу нүүлгэн шилжүүлнэ.
- Босоо тэнхлэгийн зам барихад ашигласан газрын нөхөн сэргээлтэд оруулна.
- Хүннү гүрний нийслэл, түүхэн дурсгалт "Луут хот"-ыг Мянганы замтай холбоно.
- Атаршсан газрыг малын тэжээл тариалах зорилгоор иргэдэд ашиглуулах боломжийг нээнэ.

7. Булган сум

- Үүрэн холбооны сүлжээг сайжруулж, 4G сүлжээ хамрах хүрээг нэмэгдүүлнэ.
- Зуун модны голд бетонон гүүр барина.
- Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх хүрээнд ноос ноолуур, арьс шир боловсруулах үйлдвэр байгуулна.
- Зоорь, хөргүүрийг шинээр барьж, ашиглалтад оруулна.
- Сумын төв доторх хатуу хучилттай замыг нэмэгдүүлнэ.
- Нөхөрлөлүүдийн үйл ажиллагааг дэмжин, шахмал түлшний үйлдвэрийг бий болгоно.

8. Хашаат сум

- Нуурын булангаас сумын төв хүртэл хатуу хучилттай зам тавина.

- Цайдамын музей-Хархорин чиглэлийн автозамаас сумын төврүү засмал зам тавина.
- Сумын төвийн албан байгууллага, гэр хорооллыг инженерийн шугам сүлжээнд холбоно.
- Мал нядалгааны цэгийг байгуулна.
- Сумын төвийг хатуу хучилттай замтай болгоно.
- 25 болон 60 айлын орон сууцыг шинээр барина.
- Дөрвөлжингийн рашааныг түшиглэн амралтын газар шинээр байгуулна.

9. Өндөр-Улаан сум

- Сумын төвийн албан байгууллага, гэр хорооллыг инженерийн шугам сүлжээнд холбоно.
- 400 хүүхдийн суудалтай ЕБС-ын хичээлийн байр, ЭМТ-ийн өргөтгөлийн барилгыг шинээр барих, 80 хүүхдийн дотуур байр болон спорт зааланд их засвар хийнэ.
- Хог, сэг зэм шатаах зориулалтын зуухтай болгож, хогийн цэгийн байнгын харуул хамгаалалттай болгож, 2 дахь түүхий эд авах цэгийг байгуулна.
- Атаршсан газрыг малын тэжээл тариалах зорилгоор иргэдэд ашиглуулах боломжийг нээж, малчин бурийг газар тариалангийн болон өвөлжөө хаваржааны тариалалтын газартай болгоно.
- Хөөвөр боловсруулах үйлдвэрийг шинээр байгуулна.
- Зуун салаа мод, Чулуутын хавцал, Булангийн рашаан, Жаргалантын буган чулуу, Гол мод -2 гэх зэрэг байгалийн үзэсгэлэнт болон дурсгалт газруудийг түшиглэн аялал жуулчлалын цогцолборуудийг шинээр бий болгоно.
- Шинэ төгсөгч, залуу гэр бүлийг сум орон нутагтаа суурьшуулан ажиллуулах, чадварлаг боловсон хүчнийг бүрдүүлэх зорилгоор "Сумандаа сайхан амьдаръя" аяныг эхлүүлнэ.
- 25 болон 60 айлын орон сууцыг шинээр барина.

10. Цэцэрлэг сум

- Эрүүл мэндийн төвийг шинээр барина.
- Сумын төвийн албан байгууллага, гэр хорооллыг инженерийн шугам сүлжээнд холбоно.
- Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн байранд өргөтгөл хийнэ.
- Сумын Засаг даргын тамгын газрын байрыг шинээр барина.
- Чулуут багийн "Чулуутын гол"-д гүүр тавина.
- Мухар хужирт, Цагаан толгой, Хануйн хүрэмний рашаануудыг түшиглэн аялал жуулчлалыг хөгжүүлнэ.
- Атаршсан газруудыг эргэлтэд оруулж, тэжээлийн ургамлын тариалалтыг нэмэгдүүлнэ.

11. Чулуут сум

- Сумын төв болон бүх багт худаг шинээр барьж, уст цэгийн тоог нэмэгдүүлнэ.
- Эрүүл мэндийн төв, ЕБС-ын дотуур байр, Ахмадын өргөөнд их засвар хийж тохижилтүн ажлыг хийнэ.
- Халуун ус багийн Жаргалантын ам, Чулуут гол, Зуун мод баг, сумын төвийн дээд гүүрийг шинээр барина.
- 25 болон 60 айлын орон сууц шинээр ашиглалтад оруулж төрийн албан хаагчид, сумын иргэдийг хамрах боломжийг нэмэгдүүлнэ.
- Атаршсан газруудыг эргэлтэд оруулж тэжээлийн ургамлын тариалалтыг нэмэгдүүлнэ.

- Сумын Онцгой комисст туулах чадвар өндөр автомашиныг шийдвэрлэнэ.
- Хогийн цэгийг камержуулж, хогийн машины парк шинэчлэлийг хийнэ.

12. Цэнхэр сум

- Эрүүл мэндийн төвийг шинээр барина.
- Ерөнхий боловсролын сургуулийг шинээр барина.
- Сумын төвийн албан байгууллага, гэр хорооллыг инженерийн шугам сүлжээнд холбоно.
- Үүрэн холбооны сүлжээгүй багуудийг 4G,5G сүлжээнд холбоно.
- Сумын төвийн хогийн цэгийн үйл ажиллагааг сайжруулж ангилан ялгаж дахин боловсруулах цехтэй болгоно.

13. Өгийнуур сум

- Max, сүү, арьс, шир, ноос ноолууран бүтээгдэхүүний үйлдвэр байгуулна.
- Нутгийн рашаан, усны судалгааны ажлыг хийж , эрдэст ус савлах үйлдвэр байгуулна.
- Соёлын аялал жуулчлалын цогцолборыг бий болгон, хөгжүүлнэ.
- Өгийнуурын эдийн засгийн нөөцөд тулгуурлан жилийн 4 улирлын аялал жуулчлалын төлөвлөлтийг 3 км-ээс гадагш хийх, төрөл бүрийн үйлчилгээг бий болгох
- Ойн болон мод, бут, сөөг, жимс, жимсгэний үржүүлэг үйлдвэрлэлийг бий болгоно
- Хүүхдийн иж бүрэн тоглоомын талбай бүхий цогцолбор байгуулна.
- Ахуй үйлчилгээний төв байгуулна.
- Хүүхдийн хөгжлийг дэмжих төв байгуулна.

14. Эрдэнэмандал сум

- Жишиг сум төслийг үргэлжлүүлэн, инженерийн шугам сүлжээг айл өрхтэй холбох ажлыг хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрөөр хэрэгжүүлнэ.
- Засмал замыг өргөсгөнө.
- Ноос угаах үйлдвэр байгуулна.
- Махны үйлдвэрийн үйл ажиллагааг жигдрүүлнэ.
- Хан-Өндөрийн рашаан, "Нохой унадаг"-ийн шаврыг түшиглэн сувилал байгуулж , дэд бүтцийг шийдвэрлэнэ.

15. Жаргалант сум

- Сумын төв доторх замыг хатуу хучилттай болгоно.
- Сумын төвийн албан байгууллага, гэр хорооллыг инженерийн шугам сүлжээнд холбоно.
- Төв дундах Улиастайн голд бетонон хөлтэй гүүр барина.
- Засаг даргын тамгын газрын байрыг ашиглалтад оруулна.

16. Хотонт сум

- Сумын төвийн замыг хатуу хучилттай болгоно.
- Арьс шир боловсруулах цех байгуулна.
- Цагаан сүмийн рашааныг савлаж, нутгийн бренд бүтээгдэхүүнтэй болно.
- Эрчимжсэн мал аж ахуй хөгжүүлэх жишиг фермертэй болно.
- Ахмадын рашаан сувилалтай болгохыг дэмжинэ.
- Орхон Хөөвөр багийг үүрэн холбооны 4G сүлжээтэй болгоно.
- Хадлангийн салааг иж бүрэн тоног төхөөрөмжтэй болгоно.

17. Төвшрүүлэх сум

- Соёлын төв шинээр барина.
- Малын тэжээлийн үйлдвэр барина.
- Хүнс ногоо хадгалах, зоорь барина.
- Сумын төвийн албан байгууллага, гэр хорооллыг инженерийн шугам сүлжээнд холбоно.
- Аялал жуулчлал, рашаан сувилалыг хөгжүүлнэ
- Газар тариалан эрхлэлтэд орчин үеийн дэвшилтэт, техникуудийг нэвтрүүлнэ.

18. Цахир сум

- Сумын төвийн албан байгууллага, гэр хорооллыг инженерийн шугам сүлжээнд холбоно.
- Малын тэжээлийн үйлдвэр байгуулна.
- Малын мах болон арьс шир түүхий эдийн үйлдвэр барина.
- Хогийн цэгийг шинэ стандартын шатаах зуух тавьж ангилан ялган, хогийн савжуулж ил задгай хоггүй сум болгоно.
- Тэжээлийн ургамал тариалахад шаардагдах тоног төхөөрөмжөөр хангана
- Дуусаагүй байгаа барилга байгууламжуудыг ашиглалтад оруулж сургуулийн хүүхдүүдийн сурах орчинг бүрдүүлнэ.
- Содномдаржаа уул хүртэлх зам болон таних тэмдгүүдийг сэргээн засварлаж, аялал жуулчлалын төв цогцолбор болгоно.

19. Батцэнгэл сум

- Сумын төвийн хатуу хүчилттай 4,2 км авто замын бүтээн байгуулалтыг эхлүүлнэ.
АЮА0052 9001034
- “Шинэ сүм” төслийг хэрэгжүүлнэ.
- Түүхэн аялал жуучлалыг хөгжүүлэх 3 чиглэлийн маршрутын дагуу, аялал жуучлалын дэд төвүүдийг бий болгоно.
- Баян уул багийн нутагт орших Таван салааны гарамд төмөр бетон гүүр барина.
- Шивэртийн амнаас сумын төв хүртэл хатуу хүчилттай авто замаар холбоно.
- Малчид, малчдын хоршооны мах бэлтгэлийн хөргүүртэй зоорь барина.
- Газар тариалан эрхлэлтэд орчин үеийн дэвшилтэт, техникуудийг нэвтрүүлнэ.